

ХРИСТИЙН ЗААСАН ЗҮЙЛҮҮД

Библии дэх Есүс Христийн заасан зүйлүүд нь удаан хугацааны туршид хүн төрөлхтний сүнслэг удирдамжийн эх булаг болж байсан. Аврагчийн нэмэлт сургаалууд нь судрын нэгэн боть болох—Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ болох Мормоны Номонд бий. Тэдгээр нь та нарын амьдралыг сүнслэг урмаар удирдан залснаар та нарт цаашид үргэлжлэх амар амгалан болон аз жаргалаыг авчрах болно.

Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ болох Мормоны Номын үнэгүй хувийг авахын тулд доорх Вэб Хуудас руу орох буюу захидал бичнэ үү:

ECYC ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЕНТНҮҮДИЙН СҮМ

www.mormon.org

БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТИЙН ГЭРЧЛЭЛ

Есүс Христийн
Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүм



Иосеф Смит: Бурханы Бошиглогч

Иосеф Смит 14 настай байхдаа аль сүмд нэгдэх хэрэгтэйгээ мэдэхийг хүсч байсан учраас чин сэтгэлээсээ залбиран Бурханаас асуужээ. Энэхүү залбирлын хариуд Бурхан Эцэг болон түүний Хүү Есүс Христ Иосефт үзэгдэн, түүнд Есүс Христийн үнэн Сүм газар дэлхий дээр байхгүй бөгөөд тэд үүнийг сэргээхээр өөрийг нь сонгосон гэж хэлэв.

Тэр өдрөөс эхлэн Иосеф Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг мөн хожмын өдрүүдэд Бурханы хаант улсыг дэлхий дээр байгуулахаар ажиллан, Бурханы үйлчлэлд хүчин зүтгэсэн билээ. Сүмийн итгэлтэй гишүүд Есүс Христ бол дэлхийн Аврагч болон Гэмтэлгэгч мөн гэдгийг гэрчилдэг. Өнөөдөр Есүс өөрийнхөө Сүмийг дэлхий дээрх бошиглогчдод

өгч буй илчлэлтээрээ дамжуулан удирддаг. Иосеф Смит ийм л бошиглогч байсан юм. Хэдийгээр Иосеф амьдралынхаа турийн олон зүйлийг амжилттай хийж дүүсгасан ч, хамгийн чухал амлалт нь Есүс Христийн гэрч болон шавь байх явдал байсан юм. Аврагчийн талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа бошиглогч Иосеф Смит болон Сидней Ригдон нар хамгийн сүүлд Тэр амьд! хэмээн өөрсдийн гэрчлэлээ хуваалцжээ (Сургаал ба Гэрээ 76:22).

Бошиглогчийн гэрчлэлийг Ариун Сүнсний хүчэр хүлээн авдаг хүмүүс түүний хийхээр дүүдэгдсэн ажил үнэн гэдгийг мэдэх болно. Тэд бас амар амгалан, аз жаргал нь Иосеф Смитийн шутэж, үйлчилж байсан Аврагч Есүс Христээр дамжин ирдэг гэдгийг мэдэж чадна.

Аль Сүм нь Үнэн Зөв бэ?

Иосеф Смит 1805 онд Вермонт мужийн Шэрон хотод төржээ. Энэ хүүрнэл эхлэх үед тэрээр 14 настай, гэр бүлийнхэнтэйгээ Нью-Йорк мужид амьдарч байсан ба аль сүмд нэгдэх вэ гэдэг талаар нухацтай эргэцүүлэн бодож байлаа. Доор өгүүлсэн зүйл нь Иосефийн өөрийнхөө үгээр бичсэн түүх юм.

Энэ их үймээний үед би айхтар их бодолд автан, нэн тайван бус байж . . . өөрөөсөө байнга: Юу хийх хэрэгтэй вэ? Энэ бүх сүмүүдийн аль нь үнэн бэ? эсвэл тэд бүгдээрээ худал юмуу? Хэрэв тэдний аль нэг нь үнэн бол, аль нь вэ? би хэрхэн үүнийг мэдэж чадах вэ?” гэж асуудаг байлаа.

Шашны эдгээр бүлгүүдийн маргаанаас үүссэн туйлын хүнд бэрхшээлүүдийн дор хөдөлмөрлөн байхдаа, нэг өдөр би Иаковын захидалын нэгдүгээр бүлгийн тавдугаар шүлэгт “Хэрэв та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гүйг, тэгээд түүнд өгөгдөх болно” гэснийг уншилаа.



Иосеф аль сүмд нэгдэхээ шийдэхдээ Библийс удирдамж эрсэн. Тэр тэндээс “Бурханаас гүй” гэснийг унисан.

Судрын ямар ч хэсэг үүнээс илүү хүчтэй-гээр хүмүүний зүрх сэтгэлд ирж байсан нь хэзээ ч үгүй биз ээ. Энэ нь зүрх сэтгэлийн минь мэдрэмж болгонд агуу их хүчээр нэвтрэн орох мэт санагдлаа. Бурханаас мэргэн ухааныг хүсч байгаа хүн байдаг бол тэр нь би юм гэдгээ мэдэрч, үүнийг дахин дахин эргэцүүлэн бодоод, хэрхэхээ мэдэхгүй байсан ба янз бүрийн шашны бүлэглэлүүдийн багш нар судрын нэгэн ижил хэсгүүдийг янз бүрээр ойлгож, Библийн тайлбарын талаарх асуудлууд нь ямар ч итгэл төрүүлэхгүй байсан учир байгаагаас илүү мэргэн ухааныг хүлээн авахгүй бол хэзээ ч мэдэж авч чадахгүй байв.

Эцэст нь би нэг бол харанхуй төөрөг-долддоө үлдэх, эсвэл Иаковын зааснаар “Бурханаас асуух”-аар шийдэв. Ийнхүү хэрэв Бурхан мэргэн ухаанаар дутсан хүмүүст өгөөмрөөр, буруушаалгүйгээр мэргэн ухааныг өгдөг юм бол би түүнээс асуухаар оролдоод үзэж болох юм хэмээн сэтгэл шулуудав.



Иосеф Смитийн Анхны Үзэгдэл

Би Бурханаас асууна гэсэн шийдвэрийнхээ дагуу оролдлого хийхээр ой руу явлаа. Энэ бол мянга найман зуун хорин оны хаврын эхэн үеийн цэлмэг сайхан өглөө байв. Би урьд нь хэзээ ч чангаар залбирч байгаагүй тул энэ нь амьдралын минь хамгийн анхны сэтгэл түгшээсэн оролдлого байсан билээ.

*Тэдний
нэг нь ...
нөгөөрүүгээ
заагаад—“Энэ
бол Миний
Хайрт Хүү,
Түүний Үгийг
Сонсогтун!”
хэмээв.*

Би урьдчилан төлөвлөсөн газраа ирснийхээ дараа эргэн тойрноо ажиглан хараад ганцаар байна гэдгээ мэдмэгцээ өвдөг сөгдөн, Бурханд бүх зүрх сэтгэлийнхээ хүсэл эрмэлзлийг илэрхийлж эхэлсэн юм.

Дөнгөж эхэлмэгц намайг бүхэлд нь эзэмдсэн ямар нэгэн далдын хүчинд автагдсан гайхалтай нөлөөнөөс болж хэл минь татчихсан юм шиг ярьж ч чадахгүй болов. Эргэн тойрныг маань гүн харанхуй номорч, надад тэрхэн хугацаанд гэнэт үхэх тавилан маань ирсэн мэт санагдлаа.

Намайг барьж авсан энэхүү хүчинээс өөрийгөө чөлөөлүүлэхийн тулд Бурханыг дуудахад бүх хүчээ шавхан дайчилж мөн цөхрөлд автаж, бас ийм устгал сүйрлийг урьд өмнө хүмүүний бие хэзээ ч мэдэрч байгаагүй гайхам хүч бүхий үл үзэгдэх ертөнцийн нэгэн бодит хүчинд өөрийгөө тавьж өгөхөд бэлэн болоод байсан яг тэр мөчид—энэхүү агуу түгшүүрийн яг тэр мөчид, өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана ойртох ирэхийг би харлаа.

Үүнийг хармагцаа би намайг хүлж боож байсан дайснаасаа чөлөөлөгдснөө ухаарлаа. Тэрхүү гэрэл миний дээр тогтох



Үед би агаарт зогсон буй дүрслэн хэлэхийн аргагүй сүр жавхлан, гэрэл гэгээтэй эрхэмсэг хоёр Хүнийг харсан юм. Тэдний нэг нь намайг нэрээр минь дуудан нөгөө рүүгээ заагаад надад—“Энэ бол Миний Хайрт ХҮҮ, Түүний Угийг Сонсогтун!” хэмээв.

Миний Бурханаас асуух гэсэн зорилго бол энэ бүх бүлгүүдийн аль нь зөв болохыг мэдэж, тэгснээрээ тэр бүлэгт нь нэгдэх явдал байсан юм. Би өөрийгөө удирдаж, ярьж чаддаг болмогцоо миний дээр гэрэлд зогсож буй тэр Хүмүүсээс аль бүлэг нь зөв болох, (энэ үед миний зүрх сэтгэлд бүгд

буруу гэж ерөөс бодогдсонгүй)—алинд нь нэгдэх ёстойгоо асуулаа.

Тэдгээр нь бүгд худал тул би алинд ч нэгдэх ёсгүй гэсэн хариулт авсан ба надад хандан ярьж байсан Хүн, тэд бүгдийн сүсэг бишрэл түүний нүдэнд жигшил төрүүлэм харагддаг ба сургаал номлогчид нь бүгд завхруулагчид, “Тэд намайг аман дээрээ хүндэлдэг боловч тэдний зүрх сэтгэл надаас алс хол байдаг бөгөөд тэд хүний гаргасан зарлигуудыг сургаал болгон зааж, түүний хүч чадлыг нь үгүйсгэдэг атлаа гаднаа сүсэгтэй хүний дүр эсэгдэг” гэж хэлэв.

Тэр намайг тэдний аль нэгэнд нэгдэхийг дахин хориглоод, энэ удаад бичиж болохгүй өөр олон зүйлийн талаар надад ярьсан юм. Би дахин сэхээ ороод өөрийгөө тэнгэр өөд ширтэн дээш харан хэвтэж байгаагаа мэдлээ. Гэрэл алга болоход би ямар ч хүчгүй болчихсон байсан ч удалгүй бага зэрэг хүч орж гэр лүүгээ явлаа.

Хавчлага

Иосеф Бурханыг дүүлгавартайdagаж, оришин буй сүмүүдийн алинд ч нэгдээгүй юм. Тэрээр өөрийн харсан, сонссоноо хүмүүст ярьснаасаа болж эсэргүүцэл, хавчлагад орж эхэлжээ.

Ярьсан зүйл маань шашны сургаал номлогчдын дунд миний эсрэг атаа хорслыг дэвэргэж, мөрдлөг хавчлагын шалтгаан болж энэ нь улам бүр хүчтэй болж байлаа. Хэдийгээр би хорвоо дээр бусдад үл анзарагдах, арван дөрөв, тавтай балчир хүү байсан ч өндөр хэргэм зэрэгтнүүд миний энэ нөхцөл байдал, амьдралд байр сууриа олж аваагүй намайг анзаарч, нийтийн санаа бодлыг миний эсрэг хандуулан, бүх бүлгүүд хатуу ширүүн хавчлага явуулж—намайг хавчиж хяахын тулд нэгдэцгээсэн байсныг би удалгүй олж мэдэв.

Дөнгөж арван дөрвөн нас өнгөрч яваа, хэнд ч үл анзаарагдам, өдөр тутмын ажил хөдөлмөрөөрөө тарчигхан амьдралаа залгуулж яваа хүү, тэр үеийн хамгийн алдартай шашны алдар нэртэй хүмүүсийн анхаарлыг татаж, тэдэнд хамгийн гашуун хавчлага, доромжлолын санааг төрүүлсэн нь надад маш хачирхалтай санагдан түүнээс хойш энэ тухай их бодох болсон юм. Хачирхалтай ч бай, үгүй ч бай энэ явдал миний шаналал зовлонгийн шалтгаан болсон билээ.

Гэсэн хэдий ч үзэгдэл харсан минь бодит зүйл юм. Үүнээс хойш би гэрэл харж, дуу сонссоноо үзэгдэл хэмээн тооцож, Агриппа Хааны омно өөрийгөө өмгөөлөн байгаа Паултай илүү адил хэмээн бодох болсон бөгөөд зарим нь түүнийг шударга биш, бусад нь галзуу гэж тохуурхан хараан зүхдэг байсан ч түүнд итгэсээр байсан цөөн тооны хүмүүс байсан юм. Гэвч энэ бүхэн түүний үзэгдлийн үнэн бодитойг үгүйсгэж чадаагүй юм. Тэр үзэгдэл харсан, тэр харсан гэдгээ, тэнгэрийн доорх бүх хавчлага үүнийг өөрчилж чадахгүй ба хэдийгээр тэд түүнийг үхэн үхтэл нь хавчсан ч тэр эцсийн амьсгaa автлаа гэрэл харж, түүнтэй ярилцсан дуу хоолойг сонссоныг нь бүхэл бүтэн дэлхий ч түүнд өөрөөр бодуулж, итгүүлж чадахгүй гэдгийг мэдэж байсан юм.

Би ч мөн түүнтэй адил байлаа. Үнэндээ би ч гэрэл, гэрэл дундах хоёр Хүнийг харсан бөгөөд тэд үнэн бодитойгоор надтай ярилцсан юм; энэ нь үнэн хэдий ч намайг үзэгдэл харсан хэмээн хэлсний минь төлөө үзэн ядаж, хавчиж, хараан зүхэж, миний эсрэг худал хуурмаг, хар муу бүхий л аргаар ярьсан ч би зүрх сэтгэлдээ хэлсээр л байсан. Үнэнийг хэлсний минь төлөө намайг яагаад хавчина вэ? Би үнэхээр үзэгдэл харсан бөгөөд Бурханы эсрэг зогсож чадах би хэн юм бэ, яагаад дэлхий үнэхээр харсан

зүйлээ үгүйсгэхийг надаас шаардана вэ?

Үзэгдэл харсан учир би үүнийг мэднэ, Бурхан ч үүнийг мэднэ гэдгийг мэдэх ба үүнийг үгүйсгэж чадахгүй, үгүйдээ л

үүнийг хийж зүрхлэхгүй, ингэснээрээ ядаж л Бурханыг гомдоож, буруутгал ирнэ гэдгийг мэдэж байлаа.

*Би үзэгдэл
харсан, би
үүнийг мэдэх
бөгөөд Бурхан
ч үүнийг мэднэ
гэдгийг мэдэх
ба үүнийг
үгүйсгэж
чадахгүй,
үгүйдээ л
үүнийг хийж
зүрхлэхгүй.*

Тэдний аль нэгэнд нь нэгдэх нь миний үүрэг биш бөгөөд харин цаашдын удирдамж авах хүртлээ энэ хэвээрээ үлдэн, ингэснээрээ шашны бүлгүүдийн хүрээнийхний санаа зовж буй зүйлд би сэтгэл хангалуун байх болов. Мэргэн ухаанаар дутсан хүмүүс Бурханаас гүйвал тэр буруутгалгүйгээр түүнд өгөх болно гэсэн Иаковын гэрчлэл үнэн болохыг би мэдэж авсан билээ.

Би мянга найман зуун хорин гурван оны есдүгээр сарын хорин нэгэн хүртэл жирийн л ажил хөдөлмөрөө хийж, үзэгдэл харсан гэдгээ баталсаар байсан учраас шашиш шүтлэгтэй болон шашиш шүтлэггүй хүмүүсийн нийгмийн бүхий л давхаргынхны гарг хүнд хэцүү хавчлагад зовж байлаа.

Анх үзэгдэл харснаас хойш намайг мянга найман зуун хорин гурван он хүртэл—тэр үеийн шашны бүлгүүдийн алинд нь ч нэгдэхийг хориглосон байлаа. Би тэр үед маш залуу байлаа. Найз нөхөд минь байж, элэгсэг хандаж байх ёстой хүмүүс маань намайг хавчиж байв. Хэрэв тэд намайг хууртагдсан гэж үзсэн бол намайг эзэмдсэн тэр зүйлээс хайрлан, хамгаалж, тохирсон аргаар засаж залруулах ёстой байлаа. Би бүх л төрлийн

уруу таталтанд орсон. Нийгмийн янз бүрийн давхрагатай хутгалдаж, залуу насын сул тал болон хүн төрөлхтний этгээд зангаас үүдэн үе үе олон тэнэг алдааг хийж байсан ба харамсан хэлэхэд Бурханы мэлмийд ой гутам янз бүрийн уруу таталт руу хотлögдсөн юм. Гэсэн ч үнэнээ хүлээлтээ гээд хэн ч намайг ямар нэгэн агуу их хор уршиг бүхий гэм нүглийн буруутан гэж бодох хэрэггүй. Надад хэзээ ч иймэрхүү зүйл хийх зан байгаагүй юм.

Моронайн Айлчлал

Иосеф Бурханыг харснаа үгүйсгэхээс татгалзсан тул хавчлага үргэлжилсээр байлаа. 1823 оны 9-р сарын 21-нд Иосеф унтахынхаа өмнө Бурханы өмнө өөрийнхөө байр суурийг мэдэхийг хүснэ залбирав. Тэгэхэд тэнгэр элч Моронай түүнδ үзэгджээ.



Иосеф Смитийн Анхны Үзэгдлээс хойши гүрван жилийн дараа Бурхан түүн рүү Есүс Христийн ариун сургаалыг дахин сэргээх талаар заавар өгөхөөр тэнээрийн элч Моронайг илгээсэн.

Дээр дурьдсан есөн сарын хорин нэгний борой би унтахаар хэвтсэний дараа Бүхнийг Чадагч Бурханаас бүх нүгэл, тэнэглэлүүдийг маань өршөөж, түүний өмнө ямар байр суурьтай болохыг минь мэдэхэд туслаач хэмээн залбиран асуухдаа урьд нь хүлээж авсны адил тийм тэнгэрлэг илэрхийллийг авах болно гэдэгтээ итгэл төгс байлаа.

Намайг иймэрхүү маягаар Бурханд залбирах үед өрөөнд минь гэрэл үзэгдэж, өрөөг өдрийн гэрлээс илүү гэрэлтүүлэн тодор mogц орны минь дэргэд агаарт тогтох буй хүн үзэгдэв. Учир нь түүний хөл нь шаланд хүрээгүй байлаа.

Тэрээр нүд гялбам хэлхгэр цагаан нөмрөгтэй байлаа. Энэ нь урьд миний харж байсан дэлхийн бүх зүйлээс ч цагаан байсан ба хорвоогийн ямар ч юм тийм их цагаан, гэрэлтэн цацрахгүй гэдэгт би итгэлтэй байлаа. Түүний гар бугуйнаасаа бага зэрэг дээш нүцгэн байсан ба тавхай, хөл нь шагай хүртлээ нүцгэн байлаа. Түүний толгой болон хүзүү ч мөн адил нүцгэн байв. Энгэр нь задгай байсан учраас цээж нь харагдаж, би түүнийг нөмрөгнөөс өөр хувцасгүй болохыг ойлгов.

Түүний нөмрөг хэт цагаанаар зогсохгүй тэр өөрөө ер бусын дүрслэхийн аргагүй гайхамшигтай байсан бөгөөд нүүр нь үнэхээр гэрэл мэт туяарч байлаа. Өрөө мөн адил маш их гэрэлтэй байсан ч тэр хүний эргэн тойронд байгаа шиг тийм хурц гэрэлтэй биш байв. Анх би түүнийг хараад айсан боловч удалгүй тайвширсан юм.

Тэр намайг нэрээр минь дуудаж, Бурханы өмнөөс илгээгдсэн элч бөгөөд нэрээ Моронай хэмээгээд Бурханд надаар хийлгэх ажил байгаа, миний нэр бүх үндэстэн, ястан, хэлтэнд сайнаар ч, муугаар ч яригдах буюу өөрөөр хэлбэл, бүх ард түмний дунд сайн муу аль алинаар нь хэлэгдэх болно гэлээ.

Тэрээр энэ тив дээр урьд нь оршин сууж байсан хүмүүсийн тэмдэглэл, тэдний гарал үүслийн тухай алтан ялtsууд дээр бичигдсэн нууцлагдсан нэгэн бичээс байгаа гэлээ. Тэр бас үүнд эртний оршин суугчдад Аврагчийн өгсөн мөнхийн Сайн Мэдээний бүрэн байдал агуулагдсан гэдгийг хэлсэн юм.

Тэнд бас мөнгөн хүрээнд суулгасан хоёр чулуу байсан бөгөөд цээжний хуяганд бэхэлсэн эдгээр чулуунуудыг Урим, Туммим гэж нэрлэдэг байлаа. Эрт үед ялtsуудтай хамт байсан эдгээр чулууг ашиглаж, эзэмшсэн хүмүүсийг “үзмэрч” хэмээн нэрийддэг байсан ба Бурхан тэдгээрийг ном орчуулахад зориулан бэлтгэсэн юм.

Энэ бүгдийг хэлснийхээ дараа тэр Хуучин Гэрээний бошигполуудаас иш татан ярив. Тэр эхлээд Малахийн гуравдугаар бүлгээс иш



МЭ 421 онд бошиглогч Моронай ард түүнийхээ ариун бичээсийг Күмора Толгойд булжээ. Тэр дахин амилан эргэж ирээд Иосеф Смитэд Америк тивийн эртний ориин суугчдад Аврагчийн өгсөн сайн мэдээний бүрэн дүррэн байдлыг агуулсан эртний бичээсийн тухай хэлэв. Тэр бичээс нь Мормоны Ном юм.

татав; мөн бошигполын дөрөвдүгээр буюу сүүлчийн бүлгээс иш татахад энэ нь бидний Библээс уншдагаас бага зэрэг өөр байлаа. Тэр бидний номнуудад байдаг нэгдүгээр шүлгийн ишлэлийн оронд үүнийг иш татав:

“Учрыг болгоогтун, бүх бардам байдал зууханд буй мэт шатах өдөр ирнэ, тиймээ, бүх нүгэлт зүйл хийгчид сүрэл мэт шатаагдах болно; Түмний Их Эзэн тэдэнд тэднийг үндэс мөчиргүй болтол шатаахаар ирнэ хэмээн хэлж байна” гэжээ.

Тэгээд бас тэр тавдугаар шүлгээс иш татахдаа: “Болгоогтун, Их Эзэний агуу болоод аймшигт өдөр ирэхээс өмнө би бошиглогч Елиагийн гараар Санваарыг илчлэх болно” гэж хэлэв.

Тэр бас дараагийн шүлгийг өөрчлөн “Мөн эцгүүдийнх нь хийсэн амплалтыг тэрээр хүүхдүүдийн зүрх сэтгэлд суулгах болно мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно. Хэрэв энэ нь ийм биш аваас, түүний ирэлтээр бүх л дэлхий бүрмөсөн устгагдах болно” гэж иш татав.

Үүн дээр нэмэн тэр Исаиагийн арван нэгдүгээр бүлгээс иш татахдаа энэ нь удахгүй биелийх болно гэв. Тэр бас Үйлсийн туравдугаар бүлгийн хорин хоёр, хорин гуравдугаар шүлгүүдийг Шинэ Гэрээн дээр байдагтай адилаар маш тодорхой болгон иш татсан юм. Тэрээр Христ бошиглогч байсан ба харин “Түүний дуу хоолойг сонсоогүй нь хүмүүсийн дундаас хөөгдөх болно” хэмээсэн нь биелэх өдөр боюогүй боловч энэ нь удахгүй гэлээ.

Тэр бас Иоелийн хоёрдугаар бүлгийн хорин наймдугаар шүлгийн төгсгөлөөс нь иш татан өгүүлэв. Тэрээр мөн энэ нь биелийх болоогүй ч тун удахгүй гэж хэллээ. Тэр цааш нь Харийнхан ариун сургаалыг бүрэн дүүрнээр нь хүлээн авах өдөр удахгүй хэмээн мэдэгдсэн юм. Тэр судрын өөр

олон хэсгүүдийг иш татаж, мөн энд дурьдаж боломгүй олон тайлбарыг өгүүлсэн.

Намайг түүний ярьсан ялтсуудыг авах цаг нь хараахан болоогүй байсан тул тэдгээрийг хэнд ч үзүүлэх ёсгүй гэдгийг бас

дахин хэлэв. Урим, Туммим, цээжний хуягийг ч гэсэн хэнд ч үзүүлэх ёсгүй байлаа. Хэрэв би үүнийг үзүүлбэл утсгагдах байсан ба би зөвхөн үзүүл хэмээн тушаасан хүмүүст л үзүүлэх ёстой байв. Түүнийг надтай ялтын талаар ярьж

байх үед үзэгдэл ухаан санаанд минь бууж, ялтсуудыг нууцалсан газар тодорхой сайн үзэгдсэн бөгөөд энэ газраа очоод хараад таньж байлаа.

Энэ харилцан ярианы дараа өрөөн дэх гэрэл надтай ярьж байсан хүнийг хүрээлж байхыг би харав. Энэ нь үргэлжилсээр өрөө дахин харанхуй болоход зөвхөн түүний орчин тойрон гэрэлтэж байлаа. Тэгээд агшин зуур тэнгэр өөд нэгэн хонгил нээгдэж, тэр бүрэн алга болтлоо дээш хөөрж өрөө энэ тэнгэрлэг гэрэл бий болохоос өмнөх үеийнх шиг болов.

Би энэ ер бусын болсон явдлын талаар гүн бодолд автаж, тэр онцгой элчийн надад ярьсан зүйлийн талаар гайхшран байх үед гэнэт бодол дунд минь өрөө дахин гэрэлтэй болж эхлэхийг мэдсэн бөгөөд хоромхон зуур өнөөх тэнгэрлэг элч орны минь дэргэд ирсэн байлаа.

Тэрээр эхний айлчлалын үед ярьсантайгаа адил зүйлүүдийг өчүүхэн ч өөрчлөлтгүйгээр дахин өгүүлэв. Тэрээр үүнийг үйлдээд газар дэлхий дээр өлсгөлөн, дайн

дажин, тахал зэрэг агуу их сүйрлүүдээр ирэх шүүлтүүдийн тухай надад мэдүүлж; мөн эдгээр хатуу шүүлтүүд нь газар дэлхийд энэ үе удмынханд ирэх болно гэлээ. Эдгээр зүйлийг хэлснийхээ дараа тэр бас урьдийн адил дээш хөөрөн одов.

Энэ үед сэтгэл минь маш их хөдөлсөөс нойр минь хулжин одож, оөрийн үзсэн сонссоныг гайхан биширч бодолд автан хэвтэж байлаа. Энэ үед нөгөө элч орны минь дэргэд дахин ирсэн байхыг хараад бүр гайхаж орхисон ба тэр өмнө хэлсэн бүх зүйлээ дахин давтаад, үүн дээрээ нэмэн Сатан намайг баяжих зорилгоор (эцгийн минь гэр бүлийн ядуу тарчиг байдлаас



Кумора Толгой нь Нью-Йоркийн Пальмира дахь Иосефийн аж ахуйгаас зүүн урагшаа ойролцоогоор гурван милийн зайдайтай байдал. Иосефийн үед хойд хэсгийн нь тоёсгал хэсэг нь тал хээр газар ба өмнөд хэсэг нь сийрэгхэн ой модтой газар байлаа. Гэрэл Зураг: 1907 оны 8-р сар.

үүдэн) ялтсуудыг ав хэмээн уруу татах болно гэж сээрэмжлүүлэн хэллээ. Тэр надад Бурханыг алдаршуулахаас өөр зорилгоор ялтсуудыг авах хийгээд түүний хаант улсыг байгуулахаас өөр зүйлийн нөлөөнд автвал тэдгээрийг хүлээн авч чадахгүй хэмээн хориглон хэлэв.

Энэ гурав дахь ирэлтийн дараа тэрээр өмнөхтэйгээ адил тэнгэр лүү хөөрсон ба дөнгөж сая мэдэрсэн ер бусын зүйлээ эргэцүүлэн бодохоор би улдлээ. Тэнгэрлэг элчийг гурав дахь удаагаа дээш хөөрсний

дараахан тахиа донгodoход ярилцлага маань бүхэл шөнөжингөө үргэлжилснийг би мэдсэн юм.

Удалгүй би орноосоо босч, ердийнхөөрөө хөдөлмөрлөхөөр гарч явсан боловч ажиллаж чадахгүй болтлоо бүхий л хүч чадал



Моронай дөрөвн жилийн туршилт бүр ирж залуу бошиглогчид цаашидын заафыг өгдөг байв. Тэрхүү дөрөвн жилийн дараа Иосеф ялтсуудыг хүлээн авч Мормоны Номыг орчуулж эхэлжээ.

минь шавхагдсаныг мэдрэв. Хамт ажиллаж байсан аав маань надад ямар нэг зүйл тохиолдсоныг мэдээд намайг гэртээ харь гэж хэллээ. Гэртээ харих санаатай явж эхлэв. Бидний байсан талбайн хашааг давах гэж оролдох үедээ бие минь бүр тамирдахдаа ямар ч тэнхээгүйгээр газар унан хэсэг зуур ухаан алдсан байв.

Хамгийн анхны санаж байгаа зүйл бол намайг нэрээр минь дуудсан дуу хоопой байсан юм. Би дээш хараад урьдийн адил

гэрлээр хүрээлэгдсэн өнөөх элч толгойны минь дэргэд зогсож байхыг олж харав. Тэгээд тэр надад урьд шөнө өгүүлсэн бүх зүйлээ дахин өгүүлээд намайг аав руугаа очоод түүнд хүлээн авсан зарлигууд болон үзэгдлийнхээ тухай ярихыг зарлигдав.

Би дуулгавартайгаар даган талбайд буй эцэгтээ эргэн очоод түүнд болсон бүх явдлыг дуулгалаа. Тэр үүнийг надад Бурханаас ирсэн хэмээн хариулаад явж элчийн тушаасныг гүйцэтгэ гэж хэлэв. Би талбайг орхиж ялтсуудыг нуусан хэмээн элчийн надад хэлсэн газар луу явж үүнийг үзүүлсэн үзэгдэл тодорхой байсны ачаар уг газрыг төвөггүй олсон юм.

Нандин Бичээс

Нью-Йоркийн Онтарио гүнлэгийн Манчестер тосгоны ойролцоо хөрш зэргэлдээх газруудаасаа илүү өндөр өргөгдсөн нэгэн том дов бий. Энэ довны баруун талд оройгоос нь холгүйхэн байх маш том чулуун доор чулуун хайрцганд хадгалсан ялтсууд байлаа. Энэ чулууны дээд талынх нь дунд хэсэг тойрон зузаарсан, ирмэг рүүгээ нимгэрсэн учир дунд хэсэг нь газраас нилээд товоиж ирмэг хавиараа шороонд булагдсан байлаа.

Шороог нь зайлцуулан чулууны зах доогуур хөшүүрэг хийж бага зэрэг хүч гарган өргөв. Би дотогшоо хараад элчийн мэдэгдсэнчлэн үнэхээр Урим Туммим, цээживч болон ялтсууд байхыг харав. Энэ бүхэн байсан хайрцгийг хийхдээ чулуунуудыг цементээр өрж хийсэн байлаа. Хайрцагны ёроолд хоёр чулууг зөрүүлэн тавьсан бөгөөд дээр нь ялтсууд болон бусад зүйлс тавигдсан байв.

Би тэдгээрийг гаргах гэж оролдсон боловч элч намайг хориглон, эдгээр зүйлийг

авах цаг нь болоогүй, дөрвөн жил өнгөртөл авч болохгүй гэлээ. Гэвч тэрээр намайг энэ газраа яг жилийн дараа ирэх ёстай ба тэр тэнд надтай уулзах болно гэлээ. Тэгээд наадад ялтсуудыг авах цаг нь болтол жил бүр ирж бай хэмээн хэлэв.

Тушаасан зарлигийн дагуу би жил бүрийн эцсээр энд ирдэг бөгөөд ирэх болгондоо тэнд нөгөөх л элчийг хардаг ба Их Эзэн юу хийх гэж байгаа болон эцсийн өдөр хаант

улсаа хэрхэн, ямар аргаар удирдах талаар ярилцах бүртээ түүнээс зааварчилгаа, мэдээллүүдийг авч байлаа.

Эцгийн маань санхүүгийн байдал тун хэцүү байсан тул аргагүйн эрхэнд өдрийн ажлаасаа гадна бусдад хөлслөгдөн, биеийн хүчний ажил эрхлэх шаардлагатай байв. Бид заримдаа гэртээ байж, заримдаа гадуур ажил

хийдэг байсан ба ингэж үргэлжилсэн ажилтай байснаараа тохьтой амьдарч байлаа.

Иосеф хэд хэдэн ажил хийж, гэр булийнхний-хээ тохь тухтай байдлыг хангаж байв. 1825 онд тэр Нью-Йоркийн Каунти дахь Ченандод ажилд орсон ба тэрээр тэнд Эмма Хейлтэй учирч 1827 оны 1-р сарын 18-нд гэрлэжээ.

Эцэст нь ялтсууд, Урим Туммим, цээжиковч, хуягийг авах цаг болов. 1827 оны 9-р сарын 22-нд ердийнхөөрөө жилийн эцсээр дээрх зүйлсийг нуусан газар иртэл нөгөөх тэнгэрлэг элч наадад эдгээр зүйлсийг дараах үүргийн дагуу гардуулан өгсөн юм. Би эдгээрийг хариуцах ёстай ба хэрэв би тэдгээрийг өөрийн хайнга, анхааралгүй

байдлаасаа болж үрэгдүүлбэл намайг гэсгээх болно. Би тэдгээрийг өөрийнхөө бүхий л чармайлтаар элчийг авахаар иртэл нь хадгалан хамгаалах ёстай гэв.

Үдалгүй би яагаад тэдгээрийг найдвартай хадгалж байх хатуу чанга үүрэг авсан хийгээд элч яагаад эдгээр зүйлүүдийг миний хийж гүйцэтгэх ёстай зүйлийг дууссаны дараа авах болно хэмээн хэлсэн шалтгааныг ойлгосон юм. Надад эдгээр зүйлс байна гэдгийг хүмүүс мэдмэгцээ тэднийг надаас авахаар идэвхийлэн чармайх боллоо. Бодож олсон заль мэх бүр нь энэ зорилгынх нь төлөө байв. Хавчлага нь өмнөхөөсөө илүү хэцүү бэрх болж хүмүүс боломж л гарвал наадаас энэ бүгдийг авахад байнга бэлэн байлаа. Гэвч миний гараар хийгдэх ёстай зүйлүүд нь биелэгдтэл Бурханы мэргэн ухаанаар тэдгээр нь миний гарг аюупгүй хадгалагдаж байв. Хэлэлцэж тохирсон ёсоор элч эдгээр зүйлсийг авахаар ирэхэд би тэдгээрийг түүнд гардуулан өгсөн бөгөөд тэр тэдгээрийг 1838 оны 5-р сарын 2-ны энэ өдрийг хүртэл өөрийнхөө хяналтанд байлгасаар байгаа билээ. . . .

1829 оны 4-р сарын 5-нд урьд өмнө огт харж байгаагүй Оливер Каудри гэгч манай гэрт ирэв. Тэр наадад аавын минь амьдардаг газрын ойролцоо сургуульд багшилдаг ба аав минь тэр сургуульд хүүхдүүдээ явуулдаг хүмүүсийн нэгний хувьд түүнийг гэртээ нэг улирлын турш байлгаж, гэр булийнхэн маань түүнд ялтсууд хүлээн авсан зэргээ ярьсан тул тэрээр үүний тухай асуухаар ирсэн гэдгээ хэлэв.

Ноён Каудриг ирснээс 2 өдрийн дараа (4-р сарын 7-нд) би Мормоны номыг орчуулж, тэр наадад бичиж өгч эхэлсэн юм.

1829 оны Дөрөвдүгээр сард Оливер Каудри бичээчээр ажиллах болж Иосеф Смит Мормоны Номыг Бурханы хүч чадал болон бэлгээр


орчуулж эхэллээ. Иосефийг дууссаны дараа бу-
сад хүмүүс алтан ялтсуудыг харах боломж-
той болжээ. Мөн эдгээр гэрчүүд нь “хоёр буюу
гурван гэрчийн амаар үг бүр нь тогтоогдоно”
(2 Коринт 13:1) гэсний дагуу гэрчилэлээ тэм-
дэглэн үлдээсэн юм.

Санваар Сэргээгдсэн нь

Бид орчуулгынхаа ажлыг үргэлжлүүлж байх явцдаа ялтсуудын орчуулгад дурд-
санаас мэдэж авсан нүглүүдийн ангижра-
лын төлөөх баптимсын талаар Их Эзэнээс
асууж, залбирахаар дараа сарын (1829 оны
Тавдугаар сар) нэгэн өдөр ой руу явцгаасан
юм. Бид Их Эзэнийг дуудан залбирч байх
үед тэнгэрээс цацарсан үүлэн дээр буй элч
бууж ирээд бидэн дээр гарaa тавин томи-
лохдоо ийнхүү хэлсэн юм:



1829 оны 5-р сарын 15-нд Иосеф Смит, Оливер Каудри хоёр Иохан
Баптистаар гар тавшилан Аароны Санваарыг хүлээн авчээ.



Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь 1830 оны 4-р сарын 6-нд Энгээрийн Петер Виммерийн гарын байгууладсан юм. Зургаан хүн Нью-Йоркийн шашины шинэ нийгэмлэг байгуулах шаардлагыг биелигүүслийг ойролцоогоор 60 хүн гэрчилсэн.

“Миний нөхөд үйлчлэгч та нарт
Мессиагийн нэрийн өмнөөс тэнгэрийн
элчүүдийн тохинуулалын хийгээд, наманч-
лалын сайн мэдээний, мөн нүглүүдийн
ангижралын тулд усанд умбуулалтаар
хийх баптисмын түлхүүрүүдийг атгагч
Аароны Санваарыг хүртээж байна; мөн энэ
нь Левийн хөвгүүд Их Эзэнд зөв шударга
байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхий-
гээс хэзээ ч дахин авагдахгүй байх болно.”


Тэрээр энэ Аароны Санваар нь Ариун
Сүнсний бэлгийг гар тавин өгөх хүч байх-
гүй, харин үүнийг бидэнд үүнээс хойш
хүртээгтэх ёстой гэж хэлээд тэр бидэнд явж,
баптисм хүрт хэмээн тушааж, би Оливер
Каудриг, дараа нь тэр надад баптисм хүр-
тээх ёстой гэж заалаа.

Бид үүний дагуу явж баптисм хүртэв.
Бидэнд тушаасны дагуу эхлээд би түү-
нийг, дараа нь тэр надад баптисм хүртээ-
гээд би түүний толгой дээр гарaa тавьж,
түүнд Аароны Санваар олгосны дараа тэр
миний толгой дээр гарaa тавьж, надад мөн
адил Санваарыг олгов.

Ийнхүү бидэнтэй уулзаж, бидэнд энэхүү
Санваарыг хүртээсэн мөнөөх тэнгэр
элч, Шинэ Гэрээнд Иохан Баптист хэмээн

нэрлэгддэг тэрхүү Иохан гэж өөрийгөө танилцуулав. Мөн цаг нь болохоор бидэнд хүртээгдэх Мелкизедек Санваарын түлхүүрүүдийг атгадаг Петр, Иаков, Иоханы удирдлага дор ажиллаж байгаагаа, түүнчлэн ингэснээрээ би Сүмийн анхны Ахлагч, харин Оливер Каудри хоёр дахь Ахлагч хэмээн нэрлэгдэх болно хэмээн тэр хэллээ. Энэхүү элчийн гар дор бидний томилогдон, баптисм хүртсэн нь 1829 оны 5-р сарын 15-ны өдөр байлаа.


Бид баптисм хүртсэнийхээ дараа уснаас гарах яг тэр мөчид Тэнгэрлэг Эцэгээс маань ирсэн алдарт, агуу их адислалуудыг мэдэрч билээ. Би Оливер Каудрид баптисм хүртээмэгц Ариун Сүнс түүн дээр ирэн тэрээр босч зогсоод удахгүй болох ёстой олон зүйлийг зөgnөn хэлэв. Тэгээд түүнийг наадад баптисм хүртээмэгц би бас бошиглолийн сүнстэй болон босч зогсоод Сүмийн



үүсэл, Сүм болон хүн төрөлхтний хүүхдүүдийн энэ үе удамтай холбоотой бусад олон зүйлүүдийг бошиглосон юм. Бид Ариун Сүнсээр дүүрч, авралынхаа Бурханд талархаж байлаа.

Энэ бол сайн мэдээний Сэргээлт болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн байгуулалтад хөтөлсөн зарим үйл явдлүүдүн тухай Иосеф Смитийн энгийн бөгөөд үнэн гэрчлэл юм.

Иосеф Смитийн өгүүллийн бүрэн дүүрэн тэмдэглэлийг Агуу Их Үнэт Сүвд дахь Иосеф Смит-Түүх, эсвэл History of the Church (Сүмийн Түүхийн)-ийн 1:2-79-д үзэж болно.



Мормоны Ном анх 1830 онд хэвлэгдсэн бөгөөд одоо дэлхий даяар 80 гаруй хэл дээр хэвлэгдээд байна.